

**ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага****1.1.Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гээд тус зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж, 4-т “ ...Аж ахуй эрхлэх эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж тус тус заасан.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноор иргэн, хуулийн этгээдээс салбар бүрийн чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлсэн төдийгүй эдгээр үйл ажиллагаа хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, зөвлөн зааварлах, зөрчлийг арилгуулахтай холбоотой төрийн хяналтын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр ч өргөжсөөр байна.

Төрийн хяналт шалгалт гэдэг нь өргөн агуулгаар хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэрт нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, алдаа дутагдал, зөрчил гарсан бол шуурхай илрүүлж, таслан зогсоох, үр дагаварыг арилгахад чиглэсэн төрийн үйл ажиллагааны хэлбэр юм.<sup>1</sup>

Манай улсын хувьд мэргэжлийн хяналтын байгууллагын анхны нэгжийг 1930 онд байгуулж байсан бол 2002 оноос Санхүүгийн улсын хяналт шалгалтын газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын улсын алба, Боловсролын хяналтын улсын алба, Эрүүл мэндийн хяналтын улсын алба, Байгаль орчны хяналтын улсын алба, Дэд бүтцийн хяналтын улсын алба, Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын алба, Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын улсын алба, Цацрагын хяналтын улсын алба зэрэг агентлагуудыг нэгтгэж Монгол Улсын сайд болон эрхэлсэн сайдын шууд харьяалалд Улсын мэргэжлийн хяналтын газрыг байгуулсан байна.<sup>2</sup>

Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулахаар 1995 онд Төрийн хяналт шалгалтын тухай анхны хуулийг батлан мөрдүүлсэн бол 2003 онд тус хуулийг шинэчлэн баталжээ.

<sup>1</sup> Төрийн хяналт шалгалт. Ё.Бямбатогтоох. 2005 он Улаанбаатар хот. 2 дахь хэвлэлт. 3 дахь тал.

<sup>2</sup> МХЕГ-ийн түүхэн товчоо. [www.inspection.gov.mn](http://www.inspection.gov.mn)

Төрийн хяналт шалгалтын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хийших 16 жилийн хугацаанд тус хуульд 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.<sup>3</sup>

Эдгээрээс 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт нь өөр бусад хуулийн шинэчлэлтийг дагалдуулан оруулсан нэмэлт, өөрчлөлт байсан бол 2006 онд орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын даргыг томилохтой холбоотой, 2010 онд хяналт шалгалтын ангилал, түүнийг хэрэгжүүлэх журам, хяналтын улсын байцаагчийн эрх хэмжээ зэргийг тодруулсан зохицуулалтыг нэмж хуульчилжээ.<sup>4</sup>

Өөрөөр хэлбэл, эдгээр нэмэлт, өөрчлөлт нь төрийн хяналт шалгалтын ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхээс илүүтэй салбарын бусад хуулиудын шинэчлэл, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Түүнчлэн төрийн хяналт шалгалтын тодорхой салбарын хүрээнд зохицуулж байгаа цөөнгүй хуулиуд шинэчлэгдсэн бөгөөд тус шинэчлэлийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх шинэ арга хэлбэрийг тусган зохицуулах болжээ.

Тухайлбал, Гаалийн тухай хуулийг 2008 онд, Өрсөлдөөний тухай хуулийг 2010 онд, Цагдаагийн албаны тухай хуулийг 2017 онд, Татварын ерөнхий хуулийг 2018 онд тус тус шинэчлэн баталсан байна.<sup>5</sup>

2015 онд Монгол Улсын Их Хурлаас Захиргааны хариуцлагын тухай хууль болон нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 220 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн<sup>6</sup> Зөрчлийн тухай хуулийг, 2017 онд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтын ажиллагаанаас ялган зохицуулах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг тус тус батлан мөрдүүлсэн.

Ийнхүү төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх журмыг хуулийн хүрээнд зааглан тогтоосон зохицуулалт үйлчилж эхлээд 2 жил гаруй хугацаа өнгөрч байна.

Гэвч өнөөдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалт эрх зүйн зохицуулалтын шинэчлэлээс хоцорсон төдийгүй энэ төрлийн харилцааны үндсэн зарчим, аргачлалыг тодорхойлох боломжгүй, зохицуулалтын хувьд бусад хуулиудтай зөрчилдөхөд хүрсэн байна.

Төрийн хяналт шалгалтын хуулийн хэрэгжилтэнд хийсэн үнэлгээгээр<sup>7</sup> “Тус хуулийн зохицуулалт нь хэт хязгаарлагдмал зөвхөн Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын үндэслэл, журмыг зохицуулсан нь төрийн хяналт шалгалтын тогтолцоо, түүнд хамраах хяналт шалгалтын төрөл, тэдгээрийг хэрэгжүүлэх нийтлэг стандарт, журмыг тогтоох зорилтоос гажсан, мөн салбарын онцлог нэрээр хяналт шалгалтын байгууллагууд өөртөө хэт өндөр, эрс ялгаатай эрх мэдлийг холбогдох хуулиудаар бий болгох зэрэг эрх зүйн хийдэл, зөрчлийг үүсгэхэд хүргэж, улмаар төрийн хяналт шалгалтыг хүчгүй, үр дүнгүй, зөвхөн

<sup>3</sup> “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар” үнэлгээний тайлан. 2019 он.

<sup>4</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Нэвтрэлт 2019 оны 11 дүгээр сарын 20.

<sup>5</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудас.

<sup>6</sup> Зөрчлийн тухай хуулийн төслийн танилцуулга. 2015 он. [www.parliamemt.mn](http://www.parliamemt.mn)

<sup>7</sup> “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар” үнэлгээний тайлан. 2019 он.

зөрчил илрүүлэхийн тулд урьдчилан гүйцэтгэх ажиллагаа хэлбэрээр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.“ хэмээн дүгнэжээ.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан хяналт шалгалтын ажиллагааг хэрэгжүүлэх журмыг нарийвчлах, хяналтын байгууллагын чиг үүргийг иргэдэд зөвлөн зааварчлах буюу аливаа алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгод нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

## **1.2.Хуулийн төсөл боловсруулах практик хэрэгцээ, шаардлага**

2015 оны байдлаар хяналт шалгалтыг Цагдаа, Гааль, Татвар, Мэргэжлийн хяналтын газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны хянан шалгагч, байгаль хамгаалагч зэрэг 20 гаран чиглэлд 11342 улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан хэрэгжүүлэн ажиллаж байсан <sup>8</sup> бол 2019 оны байдлаар 29 байгууллагын 216 нэгжид хамаарах 10011 орчим субъект хэрэгжүүлж байна.<sup>9</sup>

Хэдийгээр улсын бацаагч нь төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийн аль алиныг нь хэрэгжүүлэх эрхтэй ч эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх эрх хэмжээ нь хууль зүйн хувьд ялгаатай байх шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, Төрийн хяналт шалгалт(хууль, стандартыг мөрдүүлэх, алдаа дутагдал гарахаас сэргийлэх хүрээнд хүн, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх)<sup>10</sup> болон зөрчил шалган шийдвэрлэх(хууль зөрчсөн байдлыг олж тогтоож, зөрчлийн үр дагаварыг арилгуулах, хариуцлага тооцох)<sup>11</sup> ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой үндэслэл, журам ялгаатай зохицуулагдах ёстой.

Улсын хяналтын байцаагчаас зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан байдал 2017 оны сүүлийн хагас жилд 7668 , 2018 онд бүтэн жилээр 18582, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 15527 болж өссөн байна.<sup>12</sup>

Харин Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааны тайлангаас үзэхэд 2012 оны байдлаар мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас 19992 тохиолдолд холбогдох асуудлаар албан шаардлага буюу гарсан алдаа, дутагдлыг арилгах чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд даалгавар өгч ажилласан бол 2018 оны байдлаар албан шаардлагын тоо 5819 болж тоо даруй 3.5 дахин буурсан байна.<sup>13</sup>

Мэргэжлийн хяналтын байгууллага 2014 онд 2575, 2015 онд 3710, 2016 онд 5732, 2017 онд 5889, 2018 онд 4954, 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 4428 зөвлөмжийг иргэд, хуулийн этгээдэд өгч ажилласан <sup>14</sup> дүнгээс үзэхэд зөвлөмжийн тоо мөн жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна.

Үүний шалтгааныг тодруулж үзвэл төрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд өөрсдийн саналаар салбарын хуулиудад заасан хориглосон,

<sup>8</sup> Улсын Ерөнхий Прокурорын газрын статистик мэдээлэл. 2015 он.

<sup>9</sup> Улсын Ерөнхий Прокурорын газрын мэдээлэл. 2019 он.

<sup>10</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3<sup>1</sup> дүгээр зүйл.

<sup>11</sup> Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь заалт

<sup>12</sup> Улсын Ерөнхий прокурорын газрын мэдээлэл. 2019 оны 10 дугаар сар.

<sup>13</sup> Мэргэжлийн хяналтын байгууллагын тайлан. 2019 он

<sup>14</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын статистик бүртгэлийн мэдээлэл. 2019 оны 11 дүгээр сар.

хязгаарласан, эсхүл үүрэг болгосон зохицуулалттай холбоотой бүхий л алдаа дутагдлыг “зөрчил”-д тооцож Зөрчлийн тухай хуульд хуульчилснаас үндсэн чиг үүргийн хүрээнд буюу хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, түүнчлэн илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар зөвлөх, сануулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх боломжгүй болсонтой холбоотой байна.

Энэ нь бодит байдалд төрийн хяналт шалгалтыг “иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа ... хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх”, улмаар зөвлөн зааварчилахад<sup>15</sup> бус харин шийтгэл оногдуулахад илүү чиглэгдэж байгааг харуулж байна.

Түүнчлэн энэ байдал нь төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх журмыг зааглан зохицуулахыг ач холбогдолыг бууруулж, мөн процесс ажиллагаатай холбоотой хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг үүсгэж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг алдагдуулж байна.

Тухайлбал, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3<sup>1</sup>.1.2-т “Хяналт шалгалтын арга, хэлбэр”-ийг тодорхойлж, тодорхой ажиллагааг хамруулсан боловч “Шинжилгээнд дээж авах” ажиллагаанаас бусад ажиллагаа, арга хэмжээг ямаржурмаар, хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй, холбогдох дүрэм журмыг хэн батлан мөрдүүлэх нь ч тодорхойгүй байна.

Ийнхүү төрийн хяналт шалгалтын явцад хэрэгжүүлэх ажиллагааны үндэслэл, журмыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тодорхой зохицуулаагүй, салбарын хуулиудад тодорхойлсон байдал нь харилцан адилгүй өөр өөр стандарт тогтоох, хуулийн зохицуулалтаас давсан хязгаарлалтыг бий болгож, хяналт шалгалтын ажиллагааг хүн, хуулийн этгээдийн эрхийг хэт хязгаарласан хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг олгож байгааг анхаарах шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчлэлийг дангаар нь бус төрийн хяналт шалгалттай холбоотой салбарын бусад хууль болон Зөрчлийн тухай хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад чиглэсэн цогц хэлбэрээр хэрэгжүүлэх нь чухал байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

2003 онд батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хуулийн төслийг дараах агуулгаар өргөжүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна:

1. Төрийн хяналт шалгалтын тогтолцоо, түүнд хамраах хяналт шалгалтын төрлийг тогтоож, улмаар Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулагдах харилцааны хүрээ, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхой хуульчилж, нэр томъёог нэг мөр цэгцлэх;

---

<sup>15</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3<sup>1</sup> дүгээр зүйлийн 3<sup>1</sup>.1.1 дэх заалт.

2. Салбарын болон тусгай хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага нь төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгчийн хувьд баримтлан ажиллах нийтлэг үндэслэл, журмыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулж, тус салбарын хууль тогтоомжоор зохицуулж байгаа хяналт шалгалттай холбоотой зохицуулалтыг нийтлэг стандартад нийцүүлэх эрх зүйн үндэсийг бүрдүүлэх;
3. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчлэлийг дангаар нь бус төрийн хяналт шалгалттай холбоотой салбарын бусад хууль, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хооронд үүсээд байгаа давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад чиглэсэн цогц байдлаар хэрэгжүүлэх. Үүнд:
  - Зөрчлийн тухай хууль болон холбогдох салбарын хууль хоорондын зөрчил, хийдлийг арилгахад анхаарч, хяналт шалгалтын арга хэлбэрээр засах боломжтой алдаа дутагдлыг “Зөрчил”- өөс зааглан ялгаж хуульчлах;
  - Төрийн хяналт шалгалтын ажиллагааны нийтлэг арга хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх суурь стандарт буюу нийтлэг үндэслэл, журмыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай байдлаар хуульчлан тогтоох;
  - Төрийн хяналт шалгалттай холбоотой хяналтын улсын байцаагчийн хэрэгжүүлэх нийтлэг эрх хэмжээг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх хэмжээнээс ялгаатай байдлаар хуульчлах;
  - Зөрчлийн гомдол мэдээлэл, хэргийн шийдвэрлэлтийн цахим мэдээлэл, бүртгэлийн санг төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллага бүрт нэгдсэн стандартаар хөгжүүлэх.
4. Төрийн хяналт шалгалттай холбоотой харилцааг зохицуулах нарийвчилсан дүрэм, журам батлах эрх олгосон зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад<sup>16</sup> нийцүүлэн Төрийн хяналт шалгалтын болон холбогдох салбарын бусад хуульд тодорхой тусгах;
5. Хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалттай холбоотой эрх хэмжээг хэрэгжүүлэх журам буюу улсын байцаагчийн стандарт үйл ажиллагааг тодорхой хуульчлах. Тухайлбал, хяналт шалгалттай холбоотой үйл ажиллагааг явуулахын тулд өөрийгөө танилцуулах, үйл ажиллагааны зорилго, түүнийг хэрэгжүүлэх журам болон тухайн ажиллагаанд хамрагдаж байгаа хүн, хуулийн этгээдийн эрх, үүргийг тайлбарлах зэрэг наад захын стандартыг тогтоох;
6. Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнг оролцуулах, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх.

---

<sup>16</sup> Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйл.

- Энэ хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхой чиг үүргийг буюу улсын байцаагчийн бүрэн эрхэд хамаарахаас бусад бүрэн эрхийг төрийн бус мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно.” гэж хязгаарлалт тогтоосныг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн<sup>17</sup> 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.” гэсэн агуулгад нийцүүлэн өргөжүүлж, холбогдох зохицуулалтыг хуульчлах.

7. Улсын байцаагчаас төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргах эрх зүйн хэлбэр, түүний хууль зүйн хүчин чадал буюу заавал биелэгдэх шинжийг тодорхой хуульчлах;
8. Хяналтын улсын байцаагчдыг сургах буюу төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасны дагуу зөв хэрэглэх үр чадвар олгох, чадавхижуулах чиглэлээр харьяа салбар, байгууллагын удирдлагуудад үүрэг хүлээлгэх зохицуулалтыг хуульчлах.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Төрийн хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсанаар төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг зарчим, үндэслэл, журам тодорхой болж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсээд байгаа зөрчил, хийдэл арилж, нэгдсэн зохицуулалттай болно.

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэдийн эрх, эрх чөлөө хангагдахаас гадна төрийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байх зарчим хэрэгжих боломжийг бүрдүүлэх тул хүний эрхийг хангах чиглэлд эерэг үр нөлөөтэй.

Мөн тус хуулийн шинэчлэл нь салбарын бусад хуулийг хүний эрхийг хангах, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн шинэчлэх эрх зүйн шаардлагыг бий болгоно.

Түүнчлэн хяналтын байгууллага, улсын байцаагчийн мэргэжлийн үр чадвар, хариуцлага нэмэгдэхээс гадна төрийн хяналт шалгалтын чиглэлээр бүртгэл, хяналтын тогтолцоо бүрдэнэ.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой зардал гарах боловч төрийн байгууллагыг шинээр байгуулах, орон тоог нэмэгдүүлэх, бүтцийг өөрчлөх шаардлага тавигдахгүй.

Иймд хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын асуудлаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу тусгайлан үнэлгээг хийж, зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлж, дүгнэлт гаргана.

<sup>17</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудас. 2019 он.

## **Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлыг үр, сортын тухай тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, түүнчлэн 2003 онд батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулах болно.

## **Хууль санаачлагч**